



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/186

Улаанбаатар хот

Гүйцэтгэн цэнэглэсэн болон хадгалалтын баталгаат хугацаа дууссан галт хэрэглэлийг аюулгүй болгох явцад гарсан дайвар бүтээгдэхүүнийг худалдах журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.7, 14.1.9, 14.1.10 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 2021 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Гүйцэтгэн цэнэглэсэн болон хадгалалтын баталгаат хугацаа дууссан галт хэрэглэлийг аюулгүй болгох явцад гарсан дайвар бүтээгдэхүүнийг худалдах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Галт хэрэглэлийг аюулгүй болгох явцад гарган авсан дайвар бүтээгдэхүүн (тэсэрч дэлбэрэх бодис, өнгөт болон бусад төрлийн төмөрлөг)-ийг зах зээлд худалдах, түүнээс олсон орлогыг Зэвсэгт хүчний Хөгжлийн санд төвлөрүүлэхийг журамд зааснаар хэрэгжүүлэх эрхийг Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэр /Н.Энхбаялаг/-т олгосугай.

3. “Гүйцэтгэн цэнэглэсэн болон хадгалалтын баталгаат хугацаа дууссан галт хэрэглэлийг аюулгүй болгох явцад гарсан дайвар бүтээгдэхүүнийг худалдах журам”-ын хэрэгжилтийг бодлогын удирдамжаар ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /хурандаа Б.Түвшинтөр/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100402

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
08 дугаар сарын 03-ны өдрийн
А/186 дугаар тушаалын хавсралт

**ГҮЙЦЭТГЭН ЦЭНЭГЛЭСЭН БОЛОН ХАДГАЛАЛТЫН БАТАЛГААТ ХУГАЦАА
ДУУССАН ГАЛТ ХЭРЭГЛЭЛИЙГ АЮУЛГҮЙ БОЛГОХ ЯВЦАД ГАРГАН АВСАН
ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХУДАЛДАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гүйцэтгэн цэнэглэсэн болон хадгалалтын баталгаат хугацаа дууссан галт хэрэглэлийг аюулгүй болгох явцад гарсан дайвар бүтээгдэхүүнийг худалдан борлуулах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед гарсан Монгол Улсын хууль, тогтоомжоор зохицуулагдаагүй асуудлыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулан шийдвэрлүүлнэ.

1.3. Журамд заасан үйл ажиллагаанаас олсон орлогыг Зэвсэгт хүчний Хөгжлийн санд төвлөрүүлнэ.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. “Тэсэрч, дэлбэрэх бодис” гэж гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд тэсэрч, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулах аюултай химийн нэгдэл буюу механик хольц, их буу, миномётын сум, нисэх онгоцны бөмбөг, пуужин, гранат, буудлагын зэвсгийн сум, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, минэ, зарим төрлийн хүчтэй пиротехникийн хэрэгслийг;

2.1.2 “Дайвар бүтээгдэхүүн” гэж тэсэрч дэлбэрэх бодис, өнгөт болон бусад төрлийн төмөрлөг, дарийг.

Гурав. Тэсэрч дэлбэрэх бодис худалдан борлуулах

3.1. “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг баримтлан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах дайвар бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр худалдах эрхийг эдэлнэ.

3.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тэсэрч дэлбэрэх бодисыг “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хуулийн 11.1.1, 11.1.4, 12.3.1, 13.1-д заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдэд худалдан борлуулна.

3.3. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тэсэрч дэлбэрэх бодисыг худалдан авагч нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хуулийн 12.2-д заасан эрхтэй, мөн хуулийн

11.1.4-д заасан мэргэжлийн итгэмжилсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, стандартаа баталгаажуулсан хуулийн этгээд байна.

3.4. Худалдан борлуулсан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тэсэрч дэлбэрэх бодисын тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тухай бүр хүргүүлнэ.

Энэ нь тухайн мэдээллийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн санд оруулах зорилготой бөгөөд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг баримтлан 22 дугаар зүйлийн 22.4 дүгээр зүйлд заасан байгууллагууд авч ашиглахад зориулагдана.

Дөрөв. Өнгөт болон бусад төрлийн төмөрлөг худалдан борлуулах

4.1. Өнгөт болон бусад төрлийн төмөрлөгийг дахин боловсруулж үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах чиглэлээр гадаадын болон дотоодын хуулийн этгээдтэй хамтран ажиллаж болох ба эсвэл чөлөөт зах зээлийн үнээр худалдан борлуулна.

Тав. Устгах

5.1. Дахин ашиглах, худалдан борлуулах боломжгүй дайвар бүтээгдэхүүнийг Батлан хамгаалахын сайдын тушаалыг үндэслэн устгаж, нотломжийг фото зургаар баталгаажуулан тухай бүр үйлдэн устгалд оролцсон бүрэлдэхүүнээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна.

Зургаа. Хяналт тавих

6.1. Аюулгүй болгосон галт хэрэглэлээс гарган авсан, цаашид үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тэсэрч дэлбэрэх бодисыг худалдах ажиллагаанд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заалтын дагуу хяналт тавина.

6.2. “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штабын холбогдох нэгжүүдтэй хамтран Аюулгүй болгосон галт хэрэглэлээс гарган авсан дайвар бүтээгдэхүүний бүртгэлд хяналт тавина.

Долоо. Бусад

7.1. “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ нь худалдан борлуулсан тэсэрч дэлбэрэх бодисын тоо, хэмжээ болон бусад мэдээллийг агуулсан тайланг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 6, 12 дугаар сард хүргүүлнэ.